

“Гадаад хэл болох япон хэлний сурахуйн судалгаа” 16-р дугаар, 2013/12

『第二言語としての日本語の習得研究』

Мэдэхгүй ханз үгийн утгыг таамаглах стратегийн сургалт

-Утгыг таамаглах сэжүүрийн хэрэглээ ба түүний оновчтой эсэх-

Уламбаярын Цэцэгдулам

/Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль/

Хураангуй

Ханз хэрэглэдэггүй орнуудын япон хэл суралцагчдын хувьд ханз үгийг сурах нь хэцүү байдаг. Ялангуяа цаашид сурах тусам мэдэхгүй ханз үгтэй таарах нь ихэсдэг учраас тэрхүү мэдэхгүй ханз үгээ түлхүүр, хам сэдэв зэрэг төрөл бүрийн сэжүүрийг ашиглан утгыг таамаглах явдал чухал. Энэхүү судалгаанд Монголд япон хэл суралцаж буй анхан шатны суралцагчдад 9 сарын турш мэдэхгүй ханз үгийн утгыг таамаглах сургалт явуулан, түүний үр дүнг багшийн тайлбар голлосон хичээл болох уламжлалт бүлэгтэй харьцуулж судаллаа. Сургалтын үр дүнд, утгыг таамаглах даалгаврын үр дүн, тэрхүү даалгаврыг хийх үед түүний тухай хэрхэн бодож байгаа арга зэргийг цуглуулж дүн шинжилгээ хийв. Уламжлалт бүлэгтэй адил материалыг харьцуулж үзвэл, туршилтын бүлэг нь уламжлалт бүлгээс утгыг таамаглах сэжүүрийн тоо ба төрөл олон, мэдэхгүй ханз үгээ тоохгүй орхих нь бага, оновчтой таамаглаж байгаа нь илүү олон болох нь тодорхой болсон. Энэ удаагийн туршилт судалгааны үр дүнгээс утгыг таамаглах стратегийн сургалт нь явуулах боломжтой бөгөөд зөв таамаглах чадвар нэмэгдэх үр дүнтэй сургалт болох нь батлагдав.

Түлхүүр үг: сэжүүр, утгыг таамаглах стратеги, мэдэхгүй ханз үг, япон хэл сурч буй монгол суралцагчид, яриаг бодуулах арга

1. Оршил

Ханз үгийг сурах нь япон хэлээр унших, бичих чадвараар зогсохгүй ярих, сонсох чадварыг ч хамарсан япон хэлний чадварт бүхэлд нь нөлөө үзүүлдэг. Гэвч ханзгүй улсын япон хэл суралцагчдад хувьд ханз үгийг сурахад хэцүү байдаг. Тэр нь эх хэлний үсгээс өөр ханз үсгийн хэлбэр, дуудлага, утга, хэрэглээ (Каноо, 2001) зэрэг их хэмжээний мэдээлэл, ялангуяа тэдгээрийг бүрдүүлдэг нийлэмж үгүүдтэй холбоотой мэддээллийг бага цагт боловсруулж, ашиглаж чаддаг болох ёстой учраас юм.

『第二言語としての日本語の習得研究』

Ялангуяа суралцагчид япон хэлний мэдлэг ахихын хирээр зайлшгүй мэдэхгүй ханз үгтэй тулгарах нь ихэсч, түүний утгыг ойлгож авахын тулд толь бичиг ашиглах, хүнээс асуух, таамаглах зэрэг аргыг хэрэглэдэг. Гэвч хажууд нь байнга толь бичиг байж, асуухад хэлээд өгөх хүн байхгүй учраас хэлийг бодитоор хэрэглэдэг болохын тулд өөрийн япон хэлний мэдлэг ба мэдэхгүй ханз үг доторх сэжүүр болох зүйл, хам сэдэв, ерөнхий мэдлэг зэргээ ашиглан утгыг таамаглах чадвар эзэмших нь чухал юм.

Суралцагчид үгийг харахад мэддэг үг, мэддэггүй үгийн аль нэг нь байдаг. Аль нь ч байсан түүнд ханз үг орсон байвал тэр ханз нь мэддэг ханз эсвэл мэдэхгүй ханз байдаг. Ялангуяа тэр мэдэхгүй ханз үг ч янз бүр байна. Дан ханз үсэг бол “Ой”, “Хад” зэрэг түлхүүрээр нь таамаглах боломжтой зүйл байхад, “Гадаад, өөр бусад” гэдэг ханз шиг түлхүүрээс нь утгыг таамаглахад хэцүү ханз үг ч байна. Мөн хэд хэдэн ханзны нийлмэл байвал бүгдийг, эсвэл нэг ханзыг нь мэддэг тохиолдолд түүнээс ханз үгийн утгыг таамаглаж чаддаг ханз үг (“цахилгаан”, “машин” гэдэг ханз үсгийг хоёуланг нь, эсвэл аль нэгийг нь мэдэж байвал “галт тэрэг” гэж утгыг таамаглаж чадна) болон “залуу нас” мэт нийлмэл ханзнаас бүтдэг үгсийн тус тус ханз үсгийг мэддэг байсан ч бүрдүүлж байгаа ханз үгээс нь утгыг таамаглах нь хэцүү үг (Мори, Наги, 1999) байдаг. Энэхүү өгүүлэлдээ “Мэдэхгүй ханз үг” гэж томъёолон хэрэглэх нь үгийн хувьд мэдэхгүй үг бөгөөд түүн дээр бичлэгт нь ханз үсэг орсон үгийг хэлнэ. Үгийн доторх тус тусын ханз үг нь мэддэг ханз, мэдэхгүй ханз аль аль нь байна.

Суралцагчид мэдэхгүй ханз үгийн утгыг таамаглах үедээ түлхүүрээр, мөн нийлмэл ханз үг бол тус тус мэддэг ханзнаасаа таамаглах, ялангуяа ханз үгийн дуудлага болон хам сэдэв зэргийг сэжүүр болгон таамаглах зэрэг аргыг хэрэглэдэг. Бодит байдал дээр нийлмэл ханз үгээс бүрдсэн мэддэг ханз үг ба хам сэдвийн мэдээллийн аль алиныг багтаасан тохиолдолд илүү оновчтой таамаглаж чаддаг болох нь тодорхой болсон (Мори, Наги, 1999).

Анхан шатнаас нь эхлэн утгыг таамаглах стратегийн сургалтыг явуулах тохиолдолд таамаглах сэжүүр болох хам сэдвийг бүрдүүлэгч хэлний хүчин зүйлийг мэдэхгүй тохиолдол их учраас түүнийг ойлгох нь хэцүү бөгөөд улмаар танин мэдэхүйн хувьд ачаалал болдог учраас бэрхшээлтэй байдаг. Гэвч ханз үгийг таамаглах нь эхлээд хэлбэр болон түлхүүр зэрэг бүтцийг сэжүүр болгож болно. Мөн аажмаар хам сэдвийн мэдээлэлтэй нийлүүлсэн сэжүүрээр утгыг таамаглуулдаг болсон ч энэхүү

“Гадаад хэл болох япон хэлний сурахуйн судалгаа” 16-р дугаар, 2013/12

『第二言語としての日本語の習得研究』

судалгаанд оролцсон суралцагчид танин мэдэхүйн өндөр чадвар, албан ёсны боловсрол эзэмшсэн зэрэг ерөнхий мэдлэг өндөр насан хүрсэн суралцагчид бөгөөд багшийг ч оруулаад бүгдээрээ нэг эх хэлтэй зэргээс япон хэлний мэдэхгүй зүйлээ эх хэлээрээ нөхөх боломжтой. Ялангуяа багш утгыг таамаглах дасгал боловсруулахдаа анхан шатны суралцагчдын япон хэлний мэдлэгийг бодолцсон мэддэг үг, хэллэгийг ашиглах зэрэг арга хэрэглэснээр утгыг таамаглах сургалт явуулах боломжтой болсон.

Мөн ханз үсгийг сурахад бэрхшээлтэй гэгддэг ханз үсэг хэрэглэддэггүй орны суралцагчдын хувьд янз бүрийн сэжүүрийг ашиглан таамаглах боломжтой болохыг сурах эхэн үеэс нь мэдрүүлэх нь сурах үр дүнг нэмэгдүүлж, сэтгэлзүйн дарамтыг багасгах явдалтай ч холбогдоно.

Энэхүү судалгаандаа япон хэл суралцаж буй монгол оюутнуудад утгыг таамаглах стратегийн сургалт явуулж, утгыг таамаглах стратегийг (мэдэхгүй ханз үгийн утгыг таамаглах сэжүүрийг ашиглан таамаглуулах) эзэмшүүлж, оновчтойгоор утгыг таамаглах чадварыг дээшлүүлэх боломжтой эсэхийг судлах нь зорилго юм.

2. Судалгааны зорилго, зорилт

Монголын их сургуулиудын ханзтай үгийн сургалтын өнөөгийн байдал, суралцагчийн ханзтай үгийн чадварыг судалж үзэхэд, хам сэдвийн хүрээнд ханзтай үгийг хэрэглэхэд анхаарсан сургалт явагддаггүй, монголын япон хэл суралцагчдын ханзтай үгийг сурч эзэмших чадвар, ялангуяа эхийн мэдээллийг ашиглан утгыг таамаглах чадвар нэлээн доогуур байсан.

Хам сэдвээс утгыг таамаглах тухайд, Нэйшён.И.С.П (2001) англи хэл сурахад хам сэдвээс утгыг таамаглах замаар үгийг сурч эзэмших нь хамгийн чухал гэж үзсэн. Англи хэлний сургалтын тухай өмнөх судалгааны үр дүнд, суралцагч шинэ үгтэй таарахаараа заавал таамаглаад байдаггүй (Фрейза.С.А 1999, Парихахт.Т.С ба Вэйше.М 1999) ч утгыг таамаглах стратегийн сургалт нь таамаглах оролдлоготой болгож, утгыг зөв таамаглахад нөлөөлдөг гэдгийг баталжээ.

Утгыг таамаглах стратегийн өмнөх судалгаагаар, суралцагч шинэ үгийн утгыг таамаглахдаа үгийн сангийн мэдлэг, дүрмийн мэдлэг, дискурсын мэдлэг, эх хэлний мэдлэг, ерөнхий мэдлэгээ ашигладаг болох нь тодорхой харагдаж байна (Таниүчи.М

“Гадаад хэл болох япон хэлний сурахуйн судалгаа” 16-р дугаар, 2013/12

『第二言語としての日本語の習得研究』

1991, Парибахт.Т.С ба Вэйше.М 1999, Нассажи.Х 2003, Ямагата.Ж 2008). Түүнчлэн утгыг таамаглахад ашиглаж буй хам сэдэв их байх тохиолдол (Таниүчи.М ба Комори.К 2009) болон ханзны нийлэмжид мэддэг бүрдүүлбэр орсон тохиолдол (Күвахара.Ё 2008) нь таамаг илүү оновчтой зөв байхад нөлөөлдөг байна. Мөн ханзны нийлэмжийн бүрдүүлбэр болон хам сэдвийн мэдээллийг нэгтгэсэн тохиолдолд ч зөв таамаглах боломжтой байна (Мори.Я; Наги.В 1999; Мори.Я 2003; Кондо-Браун.К 2006). Токүда.М (2006) утгыг таамаглах стратегийн сургалт болон үгийг бүрдүүлж буй бүтцийн талаарх мэдлэгийг хамтатган заахын чухлыг онцолжээ.

Гэвч япон хэлний салбарт утгыг таамаглах стратегийг зааж, түүнийхээ үр дүнг тайлагнасан судалгаа хараахан байхгүй, үгийн утгыг таамаглах судалгаа ч дийлэнх нь дунд түвшний суралцагчийг хамруулсан, анхан шатны түвшний судалгаа байхгүй байна. Утгыг таамаглах стратегийг анхан шатнаас заахад, таамаглах хэрэглэгдэхүүн болох хам сэдвийг бүрдүүлж буй хэлний ойлголт нь хэцүү, хэлний мэдэхгүй хэрэглэгдэхүүн олон учраас суралцагчийн танин мэдэхүйн үйл явцад хүндрэл учирч болох талтай. Гэвч анхан шатнаас стратегийн сургалтыг нэвтрүүлэх нь эхлэн хэл сурах үйл явцыг зөв чиглэл рүү хөтлөх, урт хугацаанд үргэлжлэх хэл сурах явцыг илүү үр дүнтэй болгох ач холбогдолтой. Мөн уг судалгаанд оролцогчид танин мэдэхүйн болон ерөнхий мэдлэгийн өндөр чадвартай насанд хүрсэн, бүгд нэг хэл соёлтой учир япон хэлээрх ойлгомжгүй зүйлийг эх хэлээрээ нөхөх боломжтой. Тиймээс утгыг таамаглах даалгавар боловсруулахдаа анхан шатны суралцагчдад тохирох үг хэллэг, дүрмийн хэлбэрийг сонгох гэх мэт арга хэмжээг авч болох тул утгыг таамаглах сургалт явуулах бүрэн боломжтой юм. Энэхүү бүлэгт анхан шатны суралцагчдад таамаглах сэжүүр ашиглан шинэ үгийн утгыг таамаглах стратегийн сургалт явуулан, үр дүнг нь судлахыг зорьлоо.

Уг судалгаа нь япон хэл үзэж байгаагүй суралцагчдад анхнаас нь таамаглах сэжүүр ашиглан, шинэ үгийн утгыг таамаглах стратегийн сургалт явуулж, үр дүнг шинжлэх зорилготой ба үүний тулд бодитоор доорх хоёр зорилтот асуудлыг дэвшүүллээ.

Зорилт 1-1: Уламжлалт бүлэг болон туршилтын бүлгийн ашиглаж буй таамаглах сэжүүрт ялгаа бий эсэх

『第二言語としての日本語の習得研究』

Зорилт 1-2: Туршилтын бүлэг нь уламжлалт бүлгээс илүү олон сэжүүр ашиглан оновчтой зөв таамаглаж чаддаг болох эсэх

3. Судалгааны арга зүй

3.1. Судалгаанд оролцогчид

Энэхүү судалгаанд Монголын их сургуульд япон хэлний мэргэжлээр суралцаж буй 36 оюутан оролцсон ба түүнээс 18 оюутан уламжлалт бүлэг, 18 оюутан туршилтын бүлэгт хамрагдсан. Уламжлалт бүлэг 2008 оны 9-р сард их сургуульд орж, тэр жилийнхээ тухайн сараас 9 сарын хугацаанд ханзны хичээл хийсэн. Туршилтын бүлэг нь 2009 оны 9-р сард их сургуульд орж, тэр жилийнхээ тухайн сараас 9 сарын хугацаанд утгыг таамаглах стратегийн сургалт авсан. Судалгаанд оролцогчид их сургуульд элсэхээсээ өмнө япон хэлний орчинд байсан сурсан туршлага байхгүй, япон хэл ч сурч байгаагүй. Их сургуульд элссэний дараа “Япон хэл”-ний хичээл дэх ханзны сургалт нь 5 өдөр, 5 пар 450 минутын хичээл бөгөөд амархан мэндчилгээнээс эхлээд дүрмийг л заасан байсан. Энэ үед суралцагчид хооронд япон хэлний чадварын ялгаа байгаагүй. 2 бүлэгт тус тус 9 сарын хугацаанд (30 долоо хоног, 60 пар, 1 пар нь 90 минут) хичээл явуулсан ба үндсэн сурах бичиг нь Basic Kanji Book 500 Vol.1 байв.

Хүснэгт 1. Хоёр бүлгийн хичээл (1 пар нь 90 минутын агуулга)

Хичээлийн цаг	Ханзын тест	Мэдэхгүй ханз үгийн утгыг тайлбарлах үйл ажиллагаа	Шинэ ханз үсэг заах	Шинэ ханз үгийг бичих дасгал	Сурах бичгийн дасгал	Гэрийн даалгавар
Уламжлалт бүлэг	10 минут	Ч	40 минут	10 минут	30 минут	Сурах бичгийн дасгалаас үлдсэн дасгал, дахин давтан бичих
Туршилтын бүлэг	10 минут	40 минут	30 минут	10 минут	Х	Сурах бичгийн дасгал

3.2. Судалгааны агуулга

Дээрх зорилтдоо хүрэхийн тулд, хоёр бүлгийн суралцагчдаас “утгыг таамаглах даалгавар” ашиглан судалгаа авсан. Судалгааг хоёр бүлгийн 36 суралцагчаас

“Гадаад хэл болох япон хэлний сурахуйн судалгаа” 16-р дугаар, 2013/12

『第二言語としての日本語の習得研究』

ганцаарчлан авсан бөгөөд даалгавар гүйцэтгэх явцад дууны бичлэг хийн, тэмдэглэсэн. Зорилт 1-1-д энэхүү тэмдэглэлээс ажиглагдах таамаглах сэжүүрийн төрөл зүйл, тоонд шинжилгээ хийнэ. Зорилт 1-2-т тухайн таамгийн үнэн зөв эсэх, тэмдэглэлийн агуулгад дүн шинжилгээ хийнэ.

Утгыг таамаглах даалгаврын судалгааны тухайд, юуны өмнө суралцагчдад даалгавар болох шинэ ханзтай үгийг багтаасан 21 өгүүлбэрийг нэг нэгээр нь японоор уншуулж, улмаар өгүүлбэрийн утгыг монгол хэлээр орчуулуулсан ба орчуулахдаа зөв уншсан эсэхээс хамаарахгүйгээр утгын тухай яагаад тэгэж бодсон тухай нягтлан асуусан. Монгол хэлээр орчуулахдаа юу гэж бодсоныг нь яриулж (харилцан ярьж, тунгаан бодох арга), дууны бичлэг хийв. Дуу бичлэгээ бүгдийг бичгээр буулган, япон хэлнээ орчуулсан.

Утгыг таамаглах даалгаврын судалгааг хоёр бүлгийн 30 долоо хоногийн ханзтай үгийн сургалт дууссаны дараа, 3 сарын зуны амралт дуусах үед авсан болно. Уламжлалт бүлгээс 2009 оны 9 сард, туршилтын бүлгээс 2010 оны 9 сард авсан бөгөөд зуны амралтын хугацаанд тусгайлан сургалт явуулаагүй.

4. Судалгааны үр дүн ба дүн шинжилгээ

4.1 Зорилт 1-1: Уламжлалт бүлэг болон туршилтын бүлгийн ашиглаж буй таамаглах сэжүүрүүд

Энэ хэсэгт даалгавар гүйцэтгэх явц дахь суралцагчийн тэмдэглэлээс таамаг хэсгийг сонгон авч, түүнд ажиглагдах сэжүүрийн төрөл, тоог уламжлалт бүлэг болон туршилтын бүлгээр харьцууллаа.

Хүснэгт 2. Утгыг таамаглах даалгаврын өгүүлбэр

Ханзтай үг		Ханзтай үгийн хэлбэр, сэжүүрийн өгөгдөл	Даалгаврын өгүүлбэр (21 өгүүлбэр)
Нэг ханзтай үг	桜	△	日本では ^{はる} ,春になると桜がさきます。ピンク ^{いろ} ,色でとてもきれいです。
	握る	△	きのう ^{びょういん} ,病院へ行って, ^ね ,寝ている母の手を握りました。母の手は ^{ほそ} ,細くなっていましたが,少しあたたかかったです。
	湖	△	フブスグル ^{けん} ,県(аймаг)にはモンゴルの ^{いちばん} ,一番大きい湖があります。ここでは ^{くるま} ,車を ^{あら} ,洗ってはいけません。
	靴	×	モンゴルの女の人ハイヒールの靴をよくはきますが, ^{さいきん} ,最近 ^{うんどう} は ^ふ ,運動靴をはく人も ^ふ ,増えました。
	胃	×	きのうの ^{よる} ,夜, ^{にく} ,肉をたくさん ^た ,食べて胃が ^{いた} ,痛くなったので, ^{くすり} ,薬を ^の ,飲みました。
	香り	×	この ^{へや} ,部屋はバラの ^{はな} ,花の香りがします。トーラ先生のこうすい(үнэртэй ус)の香りです。

『第二言語としての日本語の習得研究』

Хоёр ханзтай үг	出先	○○	がいしゅつ,外出するときは出先の でんわばんごう,電話番号を かいしゃ,会社に のこ,残してください。
	目指す	○○	かれ,彼は いしゃ,医者になることを目指して毎日いっしょうけ んめい べんきょう,勉強しています。
	笑顔	○○	むすこの笑顔がとてもかわいいです。
	罰金	△○	モンゴルでは, シートベルトをしないで くるま,車を うんでん,運転した場合, 5000tg の罰金をはらわなければなりません。
	拍手する	△○	カメルトンの うた,歌がとてもすばらしかったので, お きゃく,客さんはみんな た,立って拍手をしました。
	努力する	△○	MCS の しゃちょう,社長は, はたら,働きながら だいがく,大学へ 行って, それから努力して かいしゃ,会社をつくりました。
	花瓶	○×	母が3月8日の「じよせい,女性の ひ,日」にもらったバラをガ ラスのきれいな花瓶に い,入れました。
	永住する	×○	父はモンゴルの いえ,家を う,売って, アメリカに永住するつも りです。
	教師	○×	がく,学 ぶちょう,部長のボルド先生は, 3年前までロシア ごと,語

『第二言語としての日本語の習得研究』

		の教師でした。
探偵	△×	おく,奥さんが探偵に おっと,夫の いっしゅうかん,一週間の ようす,様子 (байр байдал) について ちょうさ,調査 (судалгаа) をたのみました。
翻訳する	×△	テウムルバートルは, 「BUSHIDO」をモンゴル ^ご ,語に翻訳し て, ゆうめい,有名になりました。
禁煙	×△	だいがく,大学の中は, 禁煙です。トイレの中でタバコをすう学 生がいたら, ちゅうい,注意してください。
乾燥する	×△	あめ,雨でぬれた (норсон) ようふく,洋服をストーブ (зуух) で乾燥させました。
興奮する	××	バットさんはテストで はじ,初めて 100 点を と,取ったので興奮 しました。
邪魔する	××	べんきょう,勉強しようと おも,思うと おとうと,弟がいっしょに あそ,遊びたいとあって, いつも邪魔します。

○ Үзсэн ханз нь сэжүүр болох, △ түлхүүр нь сэжүүр болох, × сэжүүр байхгүй

3.3. Таамаг хэсгийн нэгтгэл ба сэжүүрийн төрөл

Юуны өмнө суралцагчийн утгыг таамаглах даалгаварыг хийх үеийн дууны бичлэгийн тэмдэглэлээс таамагтай холбоотой хэсгийг сонгосон. Тухайн хэсгийг таамаг гэж үзэн сонгох сонголтыг зохиогч болон өөр нэг япон хэлний монгол багш тус тусдаа хийсэн

『第二言語としての日本語の習得研究』

бөгөөд сонголт 92.0%-аар тохирч байсан. Тохироогүй хэсгийг гуравдагч багшаар дахин сонгуулж, эцсийн байдлаар зохиогч шийдвэр гаргасан.

Улмаар тухайн сонгосон таамгийн хэсэгтэй илүү нарийн танилцаж, таамаглах сэжүүрийн төрөл зүйлийг тогтоосон. Төрөл зүйлийг тогтоохдоо зохиогч өөр нэг япон багштай (10 гаруй жил багшилсан) хоёул хамтарсан бөгөөд өмнөх судалгаанаас сэжүүрийн төрөл зүйлийг түлхүү авч үзсэн Парихахт.Т.С /Paribakht, T.S./ (2009)-г баримтлан сонгосон. Хүснэгт 3-т Парихахт.Т.С (2009)-ийн таамаглах сэжүүрийн төрөл, уг судалгааны тэмдэглэлд ажиглагдсан сэжүүрийн төрөл болон тухайн тэмдэглэлийг нэгтгэлээ.

Уг судалгааны төрөл зүйл нь эцсийн байдлаар 1. Ханзтай үгийг бүрдүүлж буй элемент (цаашид *бүрдүүлэх элемент* гэх) <Үгийг бүрдүүлж буй ханз тус бүрийн түлхүүр үг зэргээс таамаглах>, 2. Ханзны дүрслэл <Шинэ ханзтай үгэнд орж буй ханзны хэлбэр дүрсээс утгыг таамаглах>, 3. Ханзтай үгэнд орж буй мэддэг ханз (цаашид *мэддэг ханз* гэх) <Үгийг бүрдүүлж буй мэддэг ханзнаас утгыг таамаглах>, 4. Холбоо үг <Шинэ ханзтай үгтэй хамт орж буй үгийн мэдлэгээ ашиглах>, 5. Өгүүлбэрийн утга <Шинэ ханзтай үгийн утгыг бүтэн өгүүлбэр болон өгүүлбэрийн аль нэг хэсгээс таамаглах>, 6. Өгүүлбэрийн хэл зүй <Шинэ ханзтай үгийн үгсийн аймаг (үйл үг, нэр үг, үйлдүүлэх хэв) гэх мэт хэл зүйн мэдлэгээ ашиглан таамаглах>, 7. Ерөнхий мэдлэг <Өгүүлбэрийн утгатай холбоотой мэдлэг болон бусад суурь мэдлэгээ ашиглах> гэсэн 7 зүйл байна. Т.С.Парихахт (2009)-ын төрөлд байгаа ч уг судалгааны төрөлд байхгүй сэжүүрийн төрлийг Хүснэгт 2 дотор (байхгүй) гэж тэмдэглэв. Түүнчлэн, уг судалгааны төрөл 1-3 нь Т.С.Парихахт (2009)-ын доод ангилал болох “үгийн хэлбэр” гэдэгт багтах боловч ханзны онцлогоос шалтгаалан дахин 3 зүйлд хуваалаа.

Нийт сэжүүрийг төрөл зүйлд хуваахдаа Хүснэгт 3-ын жишээ шиг тодорхой гарч байгаа тэмдэглэлийг гол болгон тогтоосон болно.

Хүснэгт 3. Таамаглах сэжүүрийн төрөл болон тэмдэглэлийн жишээ

Парибахт.Т.С (2009)-ийн таамаглах сэжүүрийн төрөл		Уг судалгаанд ажиглагдсан таамаглах сэжүүрийн төрөл		
		Төрөл	Тэмдэглэлийн жишээ	
Хүүжээ ийнлэх хэлгүүлэлт үнэгсэх ь.логдфдох	Хэлний төсөөлөл	(Байхгүй)		
	Хэлний хэлбэр	(Байхгүй)		
	Хэлний дүрслэл	1.Ханзтай үгийг бүрдүүлж буй элемент	<p>Даалгавар : 雨 (あめ) でぬれた洋服 (ようふく) をストーブ (ずух) で乾燥*¹させました。</p> <p>S6:その漢字には、火、品、木の漢字がありますね。火の部首がありますから、それで乾かしたのではないですか。</p>	
		2. Ханзны дүрслэл	<p>Даалгавар : きのうの夜、肉 (にく) をたくさん食べて胃が痛 (いた) くなったので、薬 (くすり) を飲みました。</p> <p>S8:肉をたくさん食べましたから。これって、「のど」ですね。「のど」の奥にありますね。この漢字は、なんとなく人の「のど」の形をしていませんか。</p>	
		3.Ханзтай үгэнд орж буй мэддэг ханз	<p>Даалгавар : 彼 (かれ) は医者 (いしゃ) になることを目指して毎日 (まいにち) いっしょうけんめい勉強 (べんきょう) しています。</p> <p>S13:指す? 目的ですね。「目」と「指す」の漢字があります。目は、目的という言葉に使われますね。</p>	
Холбоо үг	4. Холбоо үг	<p>Даалгавар : モンゴルの女の人はハイヒールの靴をよくはきますが、最近 (さいきん) は運動 (うんどう) 靴をはく人も増 (ふ) えました。</p> <p>S8:ハイヒールという言葉と女の人の話ですから。「履きま</p>		

『第二言語としての日本語の習得研究』

			す」は、靴と一緒に使われますね。
	Өгүүлбэрийн утга	5. Өгүүлбэр -ийн утга	<p>Даалгавар：外出（がいしゅつ）するときは出先の電話番号（でんわばんごう）を会社（かいしゃ）に残（のこ）してください。</p> <p>S13:電話番号を残してくださいとありますから、出張先、行き先のことですね。</p>
	Өгүүлбэрийн хэл зүй	6. Өгүүлбэр -ийн хэл зүй	<p>Даалгавар：雨（あめ）でぬれた洋服（ようふく）をストーブ（ずう）で乾燥させました。</p> <p>S1：「させました」とあるからそう思った。</p>
	Цэг таслал		(Байхгүй)
	Дискурсын утга		(Байхгүй)
	Тогтсон мэдлэг		(Байхгүй)
Эх хэлэнд тулгуурлах	Эх хэлний төсөөлөл (Холбоо үг)		(Байхгүй)
	Эх хэлний дүрслэл (Хэлний хэлбэр)		(Байхгүй)

『第二言語としての日本語の習得研究』

Хэлний бүс сэжүүр	Ерөнхий мэдлэг	7. Ерөнхий мэдлэг	<p>Даалгавар : フブスグル県 (аймаг) にはモンゴルの一番大きい湖があります。ここでは車を洗ってはいけません。</p> <p>S6 : 「フブスグル県にはモンゴルの一番大きい何かがあります。ここでは車を洗ってはいけません。」モンゴル語に訳すと、フブスグル県にはモンゴルの一番大きい湖？この場所には湖がありますからね。</p>
-------------------	----------------	----------------------	--

*1. Хүснэгт 3-т даалгаврын өгүүлбэр доторх таамаглах ханзтай үгийг тодруулсан байгаа боловч, бодит даалгаварт ямар нэгэн тэмдэглэгээ хийгээгүй.

Таамаглах сэжүүрийн тоо ба төрөл

Хүснэгт 4-т шинэ ханзтай үгийг сурч эзэмших арга болон сэжүүрийн хэрэглэгдсэн тооны дундаж үзүүлэлтийг нэгтгэв. Сурч эзэмших аргын тухайд, уламжлалт бүлэг (12.2) туршилтын бүлэг (4.8)-ээс “таамаглахгүй орхих”-ын дундаж үзүүлэлт илэрхий өндөр байв ($t(34)=4.208, p<.01$). Түүнчлэн “Таамаглах сэжүүрийн хосолмол”-ын дундаж үзүүлэлтийн хувьд туршилтын бүлэг (16.2) уламжлалт бүлэг (8.8)-ээс илт өндөр ($t(34)=4.208, p<.01$) байна.

Шинэ ханзтай үгийг таамаглахад ашигласан сэжүүрийн дотор дан болон 2 ба 3 сэжүүрийг хослуулан хамт ашигласан (хосолмол сэжүүр) байдал харагдаж байна. Дан сэжүүрийн хувьд, хоёр бүлгийн хэрэглэсэн тооны дундаж үзүүлэлтийг харьцуулахад, туршилтын бүлэг (13.2) уламжлалт бүлэг (7.4)-ээс илт өндөр ($t(34)=3.702, p<.01$) байв. Дан сэжүүрийг нарийн ажиглавал, хоёр бүлэг аль аль нь “өгүүлбэрийн утга” болон “мэддэг ханз”-ыг олон хэрэглэж байсан ба хэрэглэсэн тооны дундаж үзүүлэлтийг харахад, хоёуланд нь туршилтын бүлэг уламжлалт бүлгээс өндөр байна (“өгүүлбэрийн утга” $t(34)=2.393, p<.05$, “мэддэг ханз” $t(34)=3.434, p<.01$). Хосолмол сэжүүр хэрэглэсэн тооны дундаж үзүүлэлтийг харвал, уламжлалт бүлэг (1.4)-ээс туршилтын бүлэг (3.0) илэрхий өндөр байна ($t(34)=2.226, p<.01$). Хоёр бүлэгт хамгийн олон ажиглагдсан хосолмол сэжүүр нь “өгүүлбэрийн утга + мэддэг ханз” байсан бөгөөд энэ сэжүүрийн дундаж үзүүлэлтэнд ялгаа гарсангүй. Удаах “өгүүлбэрийн утга + бүрдүүлэх элемент” сэжүүрийн хувьд туршилтын бүлэг (0.1)-ээс туршилтын бүлэг (0.9)-ийн дундаж үзүүлэлт илт өндөр ($t(34)=3.202, p<.01$) байна. “өгүүлбэрийн утга +

『第二言語としての日本語の習得研究』

бүрдүүлэгч элемент” хосолмол сэжүүрийн хэрэглээ олон байгаагаас туршилтын бүлэгт хосолмол сэжүүрийн тоо олон давтагдаж байна.

Хүснэгт 4. Хоёр бүлгийн шинэ ханзтай үгийг сурч эзэмших арга, таамаглах сэжүүрийн хэрэглээний дундаж үзүүлэлт

Сурч эзэмших явц	Таамаглах сэжүүр		Уламжлалт бүлэг (18 суралцагч)		Туршилтын бүлэг (18 суралцагч)		
			Дундаж үзүүлэлт	Стандарт өөрчлөлт	Дундаж үзүүлэлт	Стандарт өөрчлөлт	
Таамаглах	Дан сэжүүр	1	5. Өгүүлбэрийн утга	6.3	5.0	9.8*	3.6
			3. Мэддэг ханз	0.8	1.2	2.8**	2.2
			1. Бүрдүүлэгч элемент	0.3	0.6	0.4	0.6
			6. Өгүүлбэрийн хэлзүй (нэр үг, үйл үг)	0	0	0.1	0.3
			2. Ханзны дүрслэл	0	0	0.1	0.2
			Дан сэжүүрийн дундаж	7.4	5.4	13.2**	3.9
	Хосолмол сэжүүр	2	5. Өгүүлбэрийн утга+3. Мэддэг ханз	1.2	1.8	1.5	1.4
			5. Өгүүлбэрийн утга+1. Бүрдүүлэгч элемент	0.1	0.3	0.9**	1.1
			5. Өгүүлбэрийн утга + 7. Ерөнхий мэдлэг	0.1	0.2	0.2	0.4
			5. Өгүүлбэрийн утга + 6. Өгүүлбэрийн хэлзүй (үйл үг)	0	0	0.1	0.2

『第二言語としての日本語の習得研究』

	3	5. Өгүүлбэрийн утга + 4. Холбоо үг	0	0	0.1	0.2
		3. Мэддэг ханз+1. Бүрдүүлэгч элемент	0	0	0.1	0.2
		5. Өгүүлбэрийн утга + 1. Бүрдүүлэгч элемент + 6. Өгүүлбэрийн хэл зүй (үйлдүүлэх хэв, нэр үг)	0.1	0.2	0.1	0.3
		5. Өгүүлбэрийн утга + 1.Бүрдүүлэгч элемент + 2.Ханзны дүрслэл	0	0	0.1	0.2
		Хосолмол сэжүүрийн дундаж	1.4	1.8	3.0**	2.5
Таамаглах сэжүүрийн нийт дундаж		8.8	6.3	16.2**	4.0	
Тоохгүй орхих		12.2**	6.3	4.8	4.0	

** $p < .01$ * $p < .05$

Хоёр бүлгийн сэжүүрийн төрлийг харвал, уламжлалт бүлэгт дан сэжүүр 3, хосолмол сэжүүр 4 байхад, туршилтын бүлэгт дан сэжүүр 5, хосолмол сэжүүр 9 байгаа төдийгүй, нэг удаа хэрэглэглэх сэжүүрийн тоо ч мөн олон байна. Гэхдээ хосолмол сэжүүрийн тоо цөөн тул дүгнэлт гаргах боломжгүй байна.

Туршилтын бүлэгт шинэ ханзтай үгийг таамаглалгүй орхих байдал бага, сэжүүр ашиглан таамаглах оролдлого олон байгаагаас суралцагчдад таамаглах хандлага тогтсон гэж үзэж болохоор байна. Энэ нь Фрейза.С.А (1999)-ын судалгааг бататгасан үр дүн болж байна. Мөн уламжлалт бүлэгтэй харьцуулахад туршилтын бүлгийн дан сэжүүр төдийгүй хосолмол сэжүүрийн хэрэглээ олон байгаа хандлага ажиглагдав. Эдгээр үр дүнгээс, энэ удаагийн 9 сарын турш үргэлжилсэн сургалт нь суралцагчийн хувьд шинэ ханзтай үгийн утгыг таамаглах, таамаглахдаа янз бүрийн сэжүүрийг идэвхтэй ашиглахыг сургасан үр дүнтэй сургалт болсон хэмээн дүгнэж болох юм.

3.4. Туршилтын бүлгийн сэжүүр ашиглах, утгыг таамаглах боломжууд

Зорилт 1-2-т Зорилт 1-1-ийн хүрээнд сонгож авсан тэмдэглэлийн таамаг хэсгийн оновчтой эсэх, түүний дундаж оноог хоёр бүлгээр харьцуулан гаргаж, учир шалтгааныг нь тогтоохын тулд тэмдэглэлийн агуулгад дахин чанарын шинжилгээ хийсэн.

4. 1. Таамгийн оновчтой байдлын харьцуулалт

Утгыг таамаглах даалгаврын таамгийн оновчтой эсэхийг тогтоохдоо мэдэхгүй ханзны утгыг зөв таамагласан бол 1 оноо, сэжүүр ашиглан таамагласан боловч буруу, андууран таамагласан, таамаглалгүй орхисон тохиолдолд 0 оноо өгсөн. Доорх <Таамгийн оновчтой эсэхийг тогтоосон жишээ> нь даалгавар доторх “握る” гэсэн ханзны тухай суралцагчийн харилцан ярианы жишээ (монгол хэлээр) бөгөөд тодруулсан хэсэг нь таамгийн хэсэг болно.

<Таамгийн оновчтой эсэхийг тогтоосон жишээ>

Даалгавар	きのう ^{びょういん} ,病院へ行って, ^ね ,寝ている母の手を握りました。母の手は ^{ほそ} ,細く なっていました。少しあたたかかったです。
1 оноо (оновчтой таамаг)	S10:モンゴル語に訳すと、昨日、病院へ行って、寝ている母の手を握りました？母 の手が 細くなっていました。少し暖かったです。 T:どうしてそう思いますか。 S10:母が寝ていました。また「持つ」と同じ部首があり、後ろは部屋の屋ですね。 部首から 「握る」だと思いました。
0 оноо (оновчгүй таамаг)	無視する（訳さない、文を飛ばす） A タイプ 推測を試みる（手がかりが不明） T:モンゴル語に訳してください。

『第二言語としての日本語の習得研究』

<p>S2: 昨日、母の手が痛くなりました。病院へ行って、母の手を見てもらいました。</p> <p>T: どうしてそう思いますか。</p> <p>S2: ううん、よくわかりません。次を訳していいですか。</p> <p><u>Bタイプ 推測を試みる (手がかりが示された)</u></p> <p>文の意味を手がかりとした例</p> <p>S8: 昨日、病院へ行って、寝ている母の手を温めました。しびれました？母の手が細くなって</p> <p>いました。少し暖かったです。</p> <p>T: どうしてそう思いますか。</p> <p>S8: 母の手が細くなって、温かかったとありますから、母の手を温めたと思いますね。</p> <p>部首の意味を手がかりとした例</p> <p>S6: 昨日、病院へ行って、寝ている母の手を触りました？母の手が細く、温かかったです。</p> <p>T: どうしてそう思いますか。</p> <p>S6: これですね。これは、手の部首がありますね。</p>

Таамгийн сонголтыг зохиогч болон өөр нэг япон хэлний монгол багш тус тусдаа хийсэн бөгөөд сонголт 91.8% -аар тохирч байв. Тохироогүй хэсгийг гуравдагч багшаар дахин сонгуулж, эцсийн байдлаар зохиогч шийдвэр гаргасан.

Хүснэгт 5-ын утгыг таамаглах даалгаврын онооны дундаж үзүүлэлт (нийт 21 оноо)-ийг харвал, уламжлалт бүлэг 6.6 оноо байхад туршилтын бүлэг 10.7 оноотой, дундаж үзүүлэлт илт өндөр байна ($t(34)=2.465, p<.01$). Өөрөөр хэлбэл, уламжлалт бүлэгтэй харьцуулахад туршилтын бүлэг нь утгыг илүү олон удаа зөв таамагласан байна.

『第二言語としての日本語の習得研究』

Хүснэгт 5. Хоёр бүлгийн утгыг таамаглах даалгаврын онооны дундаж үзүүлэлт (нийт 21 оноо)

Уламжлалт бүлэг (18 суралцагч)		Туршилтын бүлэг (18 суралцагч)	
Дундаж үзүүлэлт	Стандарт өөрчлөлт	Дундаж үзүүлэлт	Стандарт өөрчлөлт
6.6	5.8	10.7**	4.3

** $p < .01$

Жич, хоёр бүлгийн тэмдэглэлээс утгыг таамаглахдаа гаргасан алдааг нарийн ажиглавал, А.хэлбэр (ямар ч сэжүүр ашиглалгүй таамагласан боловч алдсан) болон Б хэлбэр (ямар нэгэн сэжүүр ашиглан таамагласан боловч алдсан) гэсэн хоёр хэлбэрт хувааж болохоор байна (Хүснэгт 6). Б хэлбэрийн хувьд уламжлалт бүлэгт 2 жишээ л байгаа бол туршилтын бүлэгт 60 жишээ байгаа нь таамаглах ородлого идэвхтэй хийжээ гэж дүгнэж болохоор байна.

Хүснэгт 6. Хоёр бүлгийн мэдэхгүй ханзтай үгийг боловсруулсан байдал

Мэдэхгүй ханзтай үгийн боловсруулалт		Уламжлалт бүлэг	Туршилтын бүлэг
Зөв таамаг		124	208
Таамаглалгүй орхисон		219	86
Буруу таамаг	А хэлбэр сэжүүр тодорхойгүй	33	24
	Б хэлбэр сэжүүр ашигласан	2	60

4.2. Оновчтой таамаглах чадвар, ашиглах сэжүүрүүд

Оновчтой таамаглахад ашигласан сэжүүрийн төрлийг авч үзье. Хүснэгт 6-д хоёр бүлгийн оновчтой зөв таамаглахдаа ашигласан сэжүүрийг үзүүлсэн бөгөөд туршилтын бүлэгт хосолмол сэжүүрийн төрөл олон ажиглагдав. Хүснэгт 7-д утгыг таамаглах бодит даалгавар болох “フブスグル^{けん}, 県 (аймаг) にはモンゴルの^{いちばん}, 一番大きい湖があります。ここでは^{くるま}, 車を^{あら}, 洗ってはいけません” өгүүлбэрийг жишээ болгон хоёр бүлгийн тэмдэглэлийг ялгааг харууллаа.

Энэхүү утгыг таамаглах даалгаврын дунд “湖” гэсэн ханзтай үгийг таамаглахад ашигласан сэжүүрийн тоо нь дан сэжүүрийн хувьд уламжлалт бүлэгт “өгүүлбэрийн утга” 7, “бүрдүүлэгч элемент” 2, туршилтын бүлэгт “өгүүлбэрийн утга” 5 байна. Хосолмол сэжүүрийн хувьд “өгүүлбэрийн утга+бүрдүүлэгч элемент” 1, туршилтын бүлэгт “өгүүлбэрийн утга+бүрдүүлэгч элемент” 7, “өгүүлбэрийн утга+суурь мэдлэг” 2, “өгүүлбэрийн утга+бүрдүүлэгч элемент+ өгүүлбэрийн хэл зүй” 1 гарч, туршилтын бүлэгт хосолмол сэжүүрийн хэрэглээ, төрөл олон байна. Энэ бол зөвхөн нэг даалгаврын жишээ бөгөөд туршилтын бүлэгт олон янзын сэжүүрийг идэвхтэй хослуулж, зөв таамаглаж чадсан нь харагдаж байна.

Мори.Я (2003)-гийн судалгаанд ханз болон хам сэдвийн мэдээллийг хослуулах нь дан ганц мэдээлэл ашигласнаас утгыг илүү зөв таамагладаг гэсэн дүн гарсан байдаг. Уг судалгааны зарим тэмдэглэлийг ажиглан харахад, ижил шинэ ханзтай үгийн таамаг байсан ч туршилтын бүлэгт олон сэжүүрийг хослуулан ашиглах хандлага ажиглагдаж байна. Зөвхөн энэхүү судалгааны дүнг нийтлэг байдлаар авч үзэх боломжгүй ч сургалтаас үүдэн ийм хандлага хүчтэй болох боломж байгаа нь харагдаж байна. (Хүснэгт 7)

Хүснэгт 7. Хоёр бүлгийн оновчтой таамаглахдаа ашигласан сэжүүр

Таамаглах сэжүүр		Уламжлалт бүлэг		Туршилтын бүлэг		
		Дундаж үзүүлэлт	Стандарт өөрчлөлт	Дундаж үзүүлэлт	Стандарт өөрчлөлт	
Дан сэжүүр	1	5. Өгүүлбэрийн утга	5.0	5.0	7.2	3.4
		3. Мэддэг ханз	0.4	1.0	1.7	1.8
		1. Бүрдүүлэгч элемент	0.1	0.3	0.2	0.4
		6. Өгүүлбэрийн хэлзүй (нэр үг, үйл үг)	0	0	0.1	0.2
	Дан сэжүүрийн дундаж		5.6	5.3	9.1*	3.7
Хосолмог сэжүүр	2	5. Өгүүлбэрийн утга + 3. Мэддэг ханз	1.2	1.8	1.3	1.3
		5. Өгүүлбэрийн утга + 1. Бүрдүүлэгч элемент	0.1	0.3	0.8	0.9
		5. Өгүүлбэрийн утга + 7. Ерөнхий мэдлэг	0.1	0.2	0.2	0.4
	3	5. Өгүүлбэрийн утга + 4. Холбоо үг	0	0	0.1	0.2
		3. Мэддэг ханз+1. Бүрдүүлэгч элемент	0	0	0.1	0.2
		5. Өгүүлбэрийн утга+1. Бүрдүүлэгч элемент+6. Өгүүлбэрийн хэлзүй (үйлдүүлэх хэв • нэр үг)	0.1	0.2	0.1	0.3

『第二言語としての日本語の習得研究』

	Хосолмол сэжүүрийн дундаж	1.4	1.8	2.5	2.2
	Нийт дундаж	6.9	6.3	11.6	4.2

** $p < .01$ * $p < .05$

Хүснэгт 8. Тэмдэглэлийн жишээ

<p>Уламжлалт бүлэг</p>	<p>Өгүүлбэрийн утга</p> <p>S2: フブスグル県にはモンゴルの一番大きな湖があります。ここでは車を……とめません。漢字は知らなかったが、フブスグル県にあるというから湖と思いました。 (ほか類似の推測 6 件)</p> <p>構成要素</p> <p>S8: フブスグル県にはモンゴルの一番大きい湖があります。「水」の部首がありますから。(ほか類似の推測 1 件)</p> <p>文の意味+構成要素</p> <p>S7: フブスグル県には湖がありますね。また、この漢字に「水」の部首があります。</p>
<p>Туршилтын бүлэг</p>	<p>文の意味</p> <p>S12: フブスグル県にモンゴルの一番大きい何があります。これは湖ですね。ここでは車を洗ってはいけませんね。「フブスグル」と「車を洗ってはいけません」とありますから。湖ですね。(ほか類似の推測 4 件)</p> <p>文の意味+構成要素</p> <p>S6: フブスグル県には、モンゴルの一番大きい湖があります。ここでは、車を洗ってはいけません。フブスグル県にあるし、この漢字には、海の漢字の部首がありますね。</p> <p>S8: フブスグル県には、モンゴルの一番大きいですか。があります。ここでは、車を洗ってはいけません。あっ、この漢字は湖ですね。水の部首とモンゴルの一番大きいとありますから、湖ですね。(ほか類似の推測 5 件)</p>

『第二言語としての日本語の習得研究』

	<p>文の意味+背景知識</p> <p>S3: フブスグル県には。モンゴルの一番大きい何かがあります。ここでは車を洗ってはいけません。大きい川ですね。でも、フブスグル県の湖が有名ですね。その湖のことですね。</p> <p>S13: フブスグル県には、モンゴルの一番大きい川、湖があります。ここでは、車を洗ってはいけません。フブスグルの湖はよく知られていますからね。</p> <p>文の意味+構成要素+文の文法（名詞）</p> <p>S9: フブスグル県には、モンゴルの一番大きい何ですか？何かがあります。ここでは、車を洗ってはいけません。フブスグル県にモンゴルの大きな湖があります。車でいけません。これ、水の部首と「があります」とありますから名詞でしょう。</p>
--	--

5. Дүгнэлт

Утгыг таамаглах стратегийн сургалт утгыг таамаглах стратегийн хэрэглээ болон таамгийн оновчтой байдалд хэрхэн нөлөөлөхийг судалсны үр дүнд туршилтын бүлэг нь уламжлалт бүлгээс илүүтэй дан болон хосолмол таамаг сэжүүрийг олноор ашиглах болж, утгыг таамаглахад хэрэглэх таамаг сэжүүрийн төрөл зүйл ч олширч, нэг удаадаа ашиглах сэжүүрийн тоо нэмэгдсэн.

Мөн туршилтын бүлэг нь уламжлалт бүлэгтэй харьцуулахад ханзны утгыг илүү оновчтой таамаглаж байгаа нь тодорхой болов.

Улмаар хоёр бүлгийн ашигласан таамаглах сэжүүрийн төрөл зүйлд анхаарч, зарим хэсгийн тэмдэглэлийг ажиглахад, адилхан шинэ ханзтай үг байсан хэдий боловч туршилтын бүлэг нь олон тооны таамаг сэжүүрийг хослуулан ашиглах гэсэн хандлага хүчтэй байгаа нь харагдаж байв.

Үүнээс үзэхэд утгыг таамаглах стратегийн сургалт явуулсан туршилтын бүлгийн суралцагч шинэ ханзтай үгтэй тулгарсан үедээ тээнэгэлзэн орхилгүй төрөл бүрийн сэжүүрийг ашиглан таамаглах гэж оролдох хандлага их байна. Түүнчлэн таамгийн оновчтой байдал ч уламжлалт бүлгээс өндөр хувьтай гарч, утгыг таамаглах

“Гадаад хэл болох япон хэлний сурахуйн судалгаа” 16-р дугаар, 2013/12

『第二言語としての日本語の習得研究』

стратегийн сургалт нь янз бүрийн сэжүүр ашиглан идэвхтэй таамаглах арга барилд хэвшүүлж, түүнийг оновчтой байхад үр дүнгээ өгсөн нь батлагдаж байна.